



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 658

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.4.3, 6.4.4, дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сэлэнгэ аймаг Мандал сум дахь Шүүхийн тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 16,945,000.00 (арван зургаан сая есөн зуун дөчин таван мянга) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Сэлэнгэ аймаг Мандал сум дахь Шүүхийн тамгын газрын дарга Д.Батсайханд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Акталж данснаас хасах хөрөнгөөс сэлбэг, хоёрдогч түүхий эд, хаягдлыг ялган тоолж сэлбэгээр худалдах, орлогыг байгууллагын дансанд төвлөрүүлэх;

2.3.Тээврийн хэрэгслийн улсын бүртгэл, татвар төлөгчийн бүртгэлээс хасуулж, хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Арга хэмжээний биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2025 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

133002602
28-r_huraldaan.docx



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн
658 дугаар тогтоолын хавсралт

СЭЛЭНГЭ АЙМАГ МА-НДАЛ СУМ ДАХЬ ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГӨ

Д/д	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон огноо	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Isuzu Bighorn, СЭҮ 77-69	ширхэг	1	16,945,000.00
Нийт дүн				16,945,000.00
				(арван зургаан сая есөн зуун дөчин таван мянга)